


АГУУЛГА

1	ДҮГЭЭР БҮЛЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	2
2	ДУГААР БҮЛЭГ. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ- ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	3
2.1	Газрын гадарга	3
2.2	Геологийн тогтоц	4
2.3	Тектоникийн нөхцөл.....	4
2.4	Газар доорх ус	4
2.4.1	Газар доорх усны найрлага шинж чанар	5
2.5	Гадаргын усан сүлжээ.....	6
2.6	Уур амьсгалын нөхцөл	7
2.6.1	Агаарын чанар.....	7
2.6.2	Дуу шуугианы түвшин	7
2.7	Хөрсөн бүрхэвч	8
2.7.1	Хөрсний тархалт	8
2.7.2	Хөрсний бохирдол, элэгдэл, эвдрэлийн одоогийн байдал.	10
2.8	Ургамлан нөмрөг.....	13
2.9	Амьтны аймаг	16
2.10	Тусгай хамгаалалттай газар нутаг	16
2.11	Соёлын өв	16
2.12	Нийгэм эдийн засгийн байдал	17
3	ДУГААР БҮЛЭГ. ТӨСЛИЙН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛҮҮД.....	17
4	ДҮГЭЭР БҮЛЭГ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ.....	19
5	ДУГААР БҮЛЭГ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	20
6	ДУГААР БҮЛЭГ. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	24
7	ДУГААР БҮЛЭГ. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	25
8	ДУГААР БҮЛЭГ. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ ...	26
9	ДҮГЭЭР БҮЛЭГ. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	28
10	ДУГААР БҮЛЭГ. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	30
11	ДҮГЭЭР БҮЛЭГ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	35
12	ДУГААР БҮЛЭГ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	36
13	ДУГААР БҮЛЭГ. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ТӨСӨВ.....	37

1 ДҮГЭЭР БҮЛЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

10 МВт нарны цахилгаан станц нь Дархан-Уул аймгийн Дархан сумын урд хилтэй залгах Хонгор сумын 1-р багийн нутаг дэвсгэрт төмөр болон авто замын сүлжээний зүүн, зүүн хойд хэсэгт тэдгээрээс холгүй, Дархан–Эрдэнэтийн 220 кВ-ын дэд станцын баруун талд 29.18 га талбайд байрлана.



1.1-р зураг. Хонгор сум дахь Нарны цахилгаан станцын байршлын зураг

Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт байрлах 10 МВт-ын нарны цахилгаан станц /НЦС/ нь жилдээ 15.2 сая киловатт эрчим хүч үйлдвэрлэх хүчин чадалтай ба нь Дарханы 220/110/35 кВ-ын дэд станцад 110 кВ-ын ЦДАШ-аар холбогдон ажилладаг. 310 Вт чадалтай 32274 ширхэг нарны зай, ДС холболтын хайрцаг 153 ш, 630 кВт-ын чадалтай инвертер 16 ш, 1600 кВА чадалтай 0.4/10 кВ-ын трансформатор 8 ш, 11 МВА хүчний трансформатор 1 ш зэрэг үндсэн тоног төхөөрөмжүүдтэй. Уг станц нь 2017 оны 1-р сарын 1-нээс эхлэн Төвийн Эрчим хүчний системд цахилгаан эрчим хүчийг үйлдвэрлэн нийлүүлж үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн ба үйл ажиллагаа явуулж эхэлснээсээ хойш нийт 67 мянган киловатт цахилгаан үйлдвэрлэж хэрэглэгчдэд хүргэсэн. 2020 оны байдлаар 12,497.67 тонн CO₂ -ийг бууруулан ажиллаж Монгол–Япон улсын байгаль орчны яамаар баталгаажуулсан.

2 ДУГААР БҮЛЭГ. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

2.1 Газрын гадарга

Нарны цахилгаан станцын талбай нь хотгор гүдгэрийн гарал үүслийн хувьд элэгдэл–хуримтлалын нам толгодод хамаарагдана. Газрын гадаргад өмнө үйл ажиллагаа явуулаагүй байх үед талбайн баруун хойд болон зүүн хэсгээр зүүн хойноос баруун урагш чиглэсэн шороон зам, баруун урд хэсгээр цахилгаан дамжуулах дэд станц руу явдаг авто шороон замууд, мөн талбайд ухагдан орхигдсон бага зэрэг хонхор зэргээс өөр гадаргын элэгдэл, эвдрэлд ороогүй байсан. Харин Нарны станц барьсны дараа талбайн баруун хэсэгт шороон замуудын элэгдэл улам нэмэгдсэн байна. Мөн НЦС-ын сүлжээний инвертерийн орчим элэгдэл үүссэн.



2.1-р зураг. Талбайд үүссэн элэгдэл, эвдрэлийн байдал

2.2 Геологийн тогтоц

Нарны станцын талбайд голоцены настай делюви–пролювийн гарал үүсэлтэй сэвсгэр хурдас тархсан. Уг хурдас нь тоосорхог элс, хайргархаг элсэнцрээс тогтох ба зузаан нь 2.0-8.0 м-ийн хооронд хэлбэлзэнэ. Тоосорхог элсний хувьд хэмхдэс материал бараг агуулаагүй (0.8 %), хувийн жин 2.66 г/см^3 , эзлэхүүн жин 1.69 г/см^3 , элсэнцрийн хувьд хувийн жин 2.66 г/см^3 , эзлэхүүн жин 1.71 г/см^3 . Онцлог нь хөлдөхдөө сулавтар овойлт үүсгэнэ.

2.3 Тектоникийн нөхцөл

Ж.Бямбын Монголын геодинамикийн дүүрэгчлэлээр эх газрын структур бүхий тавцан дундын нум бөгөөд тасралтгүй ялгарсан шүлтлэгдүү вулканит болно. Газар хөдлөлийн идэвхжил MSK шатлалаар 7 балл хүртэл доргих бүсэд багтана.

2.4 Газар доорх ус

Нарны станцын талбай нь голоцены настай делюви-пролювийн хурдас дахь уст давхаргатай. Уг уст давхаргад нарны цахилгаан станцын нарны зайн гадаргууг цэвэрлэх мод услах, унд ахуйдаа хэрэглэх зэрэг усны хэрэглээгээ хангахаар 2019 онд гүний худаг /худгийн координат: $105^{\circ} 56' 38.73'' \text{ E}$, $49^{\circ} 23' 56.67'' \text{ E}$ / гаргуулсан. Тус худаг нь 90 м гүнтэй, усны түвшин нь 32 м, ундарга нь 0.9 л/с байна.

Нарны цахилгаан станцын нийт усны хэрэглээ нь хоногт дунджаар 1-2 тн ус хэрэглэнэ. Худаг гаргаснаас хойш буюу 2020 оны усны хэрэглээг тооцож үзэхэд хоногт 1288 л буюу $1.3 \text{ м}^3/\text{х}$ ус хэрэглэсэн байна.

Нарны зайн нүүрийн шилийг 4–10 -р сард 1 удаа усаар шүршин цэвэрлэнэ. Бусад сарууд буюу хүйтний улиралд хуурай цэвэрлэгээ хийнэ. Нарны станцын цэвэрлэгээнд хийхдээ цаг агаарын байдал шороо, тоос, бороо болон шувууны сангас зэргээс хамааран сард харилцан адилгүй хэмжээтэй ус хэрэглэх ба 1 модуль секц угаахад 3-4 өдөр болдог ба нэг удаагийн цэвэрлэгээнд дунджаар 30-40 тонн ус тус тус хэрэглэнэ. Энэ нь хоногт 10 м^3 усны хэрэглээ үүсэж болохоор байгаа бөгөөд энэ үед усны боломжит нөөцийн 12 орчим хувийг ашиглах тооцоо гарч байна.

2.1-р хүснэгт. Усны зарцуулалт (2017-2020 он)

№	Нэр	Хэмжих нэгж	2017 он	2018 он	2019 он	2020 он
1	Хэрэглээний ус	л	5199	4543	2033	5501
2	Нарны зайн цэвэрлэгээ	л	1000	7000	67300	35000
3	Ариун цэврийн ус	л	40800	31100	32050	32120
4	Мод услах ус	л	51000	14600	55500	20800
5	Хүлэмжний ус	л				86000
Нийт			97999	57243	156883	179421
Хоногт ашигласан усны хэмжээ		л	385.474	839.54	626.03	1287.98

2.4.1 Газар доорх усны найрлага шинж чанар

Станцын талбай дахь худгийн ус нь химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонат-сульфатын ангийн, натри-магнийн бүлгийн, 2-р төрлийн, чанарын хувьд цэнгэгдүү, хатуувтар устай.

Усны химийн бүрэлдэхүүн нь:

$$M0.7 \frac{HCO_3 40 * SO_4 40 * Cl 19}{(Na + K) 40 * Mg 34 * Ca 26} \quad PH \ 7.36$$

2.2-р хүснэгтэд Геоэкологи газар зүйн хүрээлэнгийн Усны шинжилгээний лабораторид шинжлүүлсэн худгийн усны шинжилгээний дүнг харуулав.

2.2-р хүснэгт. Усны шинжилгээний дүн

№	Элемент	Нэгж	2023 оны шинжилгээний дүн	2024 оны шинжилгээний дүн	Зөвшөөрөгдөх хэмжээ /MNS 0900:2018/
Анион					
1	Хлорид (Cl ⁻)	мг/дм ³	51.5	71.0	350
		мг-экв/дм ³	1.35	2.00	
		мг-экв%	20.81	19.3	
2	Сульфат (SO ₄ ²⁻)	мг/дм ³	65.0	200.0	500
		мг-экв/дм ³	1.35	4.17	
		мг-экв%	19.43	40.2	
3	Нитрит (NO ₂ ⁻)	мг/дм ³	0.0	0.0	1
		мг-экв/дм ³	0.0	0.0	
		мг-экв%	0.0	0.0	
4	Нитрат (NO ₃ ⁻)	мг/дм ³	4.0	0.0	50
		мг-экв/дм ³	0.06	0.0	
		мг-экв%	0.93	0.0	
5	Карбонат (CO ₃ ²⁻)	мг/дм ³	0.0	0.0	
		мг-экв/дм ³	0.0	0.0	
		мг-экв%	0.0	0.0	
6	Гидрокарбонат (HCO ₃ ²⁻)	мг/дм ³	250.1	256.2	
		мг-экв/дм ³	4.1	4.2	
		мг-экв%	58.83	40.5	
Катион					
7	Натри (Na ⁺ +K ⁺)	мг/дм ³	10.6	95.7	200
		мг-экв/дм ³	0.46	4.16	
		мг-экв%	6.62	40.1	
8	Кальци (Ca ²⁺)	мг/дм ³	53.1	54.1	100
		мг-экв/дм ³	2.65	2.7	
		мг-экв%	38.03	26.0	
9	Магни (Mg ²⁺)	мг/дм ³	40.8	42.6	30
		мг-экв/дм ³	3.85	3.5	
		мг-экв%	55.25	33.8	
10	Аммони (NH ₄ ⁺)	мг/дм ³	0.1	0.1	1.5
		мг-экв/дм ³	0.01	0.01	
		мг-экв%	0.08	0.1	

№	Элемент	Нэгж	2023 оны шинжилгээний дүн	2024 оны шинжилгээний дүн	Зөвшөөрөгдөх хэмжээ /MNS 0900:2018/
11	Төмөр (Fe ²⁺)	мг/дм ³	0.0	0.0	0.3
		мг-экв/дм ³	0.0	0.0	
		мг-экв%	0.0	0.0	
12	Төмөр (Fe ³⁺)	мг/дм ³	0.0	0.0	0.3
		мг-экв/дм ³	0.0	0.0	
		мг-экв%	0.0	0.0	
Үзүүлэлтүүд					
13	Анионуудын нийлбэр	мг/дм ³	481.2	719.7	1000
14	Ерөнхий хатуулаг	мг-экв/дм ³	6.5	6.2	7
15	Эрдэсжилт	ppm	326	558	1000
16	Цахилгаан дамжуулах чадвар	S/cm	693	1014	
17	Тунгалаг	см	>30	>30	
18	pH		7.16	7.36	6.5-8.5
19	Үнэр		үгүй	үгүй	
20	Өнгө		үгүй	үгүй	

Шинжилгээний дүнгээс үзэхэд магнийн ионы агууламж нь “Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900:2018”-д заасан хэмжээнээс ялимгүй их гарсан байна.

2.5 Гадаргын усан сүлжээ

Төслийн талбайд гадаргын урсцаар гуу жалга үүсээгүй байна. Талбайн баруун талд 1.9 км-т Хараа гол урсах ба талбайн бусад чиглэлд байнгын урсацтай усны эх үүсвэр байхгүй. Энэ талбай нь шар усны болон зуны хур борооны үерийн урсац орж ирэхдээ талбайн ихэнх хэсэгт нил урсац байдалтай байдаг.

Хараа голын усны химийн найрлага шинж чанар. Хараа голын ус нь 2018 оны байдлаар эрдэсжилт 260.5-259 мг/л, хатуулаг 2.61 мг/л найрлагын хувьд зөөлөн ус байна. Усны бохирдлын индексээр “цэвэр” гэсэн ангилалд үнэлэгдсэн. Хараа голын усны химийн шинжилгээний дүнг 2018 оны жилийн эцсийн байдал болон 2021 оны 04 дүгээр сарын 13-нд тодорхойлсон дүнг харахад 2018 оны жилийн дундаж, 2021 оны 4-р сарын агууламж нь MNS 4586:98 усны чанарын стандарттай харьцуулахад зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс давсан бохирдолгүй байсан ба шинжилгээний дүнг дараах хүснэгтээр харуулав.

2.3-р хүснэгт. Хараа голын усны гол бохирдуулагч үзүүлэлтүүдийн агууламж, мг/л

Үзүүлэлтүүд	Гадаргын усны стандарт /MNS 4586-1998/	Олон жилийн дундаж	2013 оны байдал	2024 оны 11-р сарын байдал
O_2	4<6	9.54	9.42	12.64
BXX_5	3	2.41	2.29	2.7
ПИЧ	10	3.3	3.4	5.8
NH_4	0.5	0.23	0.26	0.19
NO_2	0.02	0.013	0.007	0.003

NO ₃	9.0	0.36	0.38	
P _{эрд}	0.1	0.095	0.140	0.007

2.6 Уур амьсгалын нөхцөл


Талбай орчмын нутаг дэвсгэр нь хахир хүйтэн өвөлтэй, чийглэгдүү, дулаавтар зунтай, хуурайдуу хахир хавартай, чийглэгдүү нарлаг, сэрүүн намартай. Эх газрын эрс тэс уур амьсгалын шинж улирлаар тод илэрч байдаг.

2.6.1 Агаарын чанар

Төслийн талбай руу бохир агаарын тархалт үүсгэх гол эх үүсвэр нь Дархан хотын гэр хороолол, зарим орон сууц барилгын халаалтын зуухнууд үйлдвэрийн район, хотын тээврийн хэрэгсэл, Дарханы төмөрлөгийн үйлдвэрийн утаа, төмрийн баяжмалын үйлдвэрүүдээс гарах утаа зэргээс гадна ДЦС-ын утаа байж болох юм. Эдгээр нь орон нутгийн улирал, хоногоор өөрчлөгдөх салхины горимоос ихээхэн хамаарах онцлогтой байхаар байна. Үүнээс гадна орчны тоосжилтыг нэмэгдүүлдэг нэг гол хүчин зүйл бол шороон шуурга юм. Шороон шуурганы тоосны нарны зайн нүүрэнд бууж эрчим хүч үйлдвэрлэлийн хэмжээг бага боловч бууруулах нөлөө үүснэ. Тоосжилт үүсэх талбайг багасгахад анхаарах хэрэгтэй.

2.6.2 Дуу шуугианы түвшин

Хэмжилтийн дүнгээс үзэхэд дуу шуугианы дундаж түвшин 28.5-52.5 дБА-ын хооронд хэлбэлзэж байсан ба талбайн баруун хэсэгт цаг үеийн байдлаас хамааран авто болон төмөр замын хөдөлгөөн бага байгаа учир дуу шуугианы түвшин нь бага байна. Судалгааны талбай нь үйлдвэр, дэд бүтцийн /зам, эрчим хүчний/ сүлжээний дунд байрлах бөгөөд түүнд Улаанбаатар-Сэлэнгэ, Дархан-Шарын голын төмөр зам болон Дулааны цахилгаан станц зэрэг объектууд нь хэвийн үйл ажиллагаатай болох үед төслийн талбай орчимд дуу шуугиан нэмэгдэж болзошгүй. Харин талбайн зүүн хэсэгт цахилгаан дамжуулах дэд станцын тоног төхөөрөмжийн дуу чимээнээс шалтгаалан дуу шуугианы түвшин их байж болно. Эдгээр түвшнүүд нь Монгол улсын MNS 4585:2016 стандартыг даваагүй байна. Ажилчдын ажлын байр болон инвертерийн байр дотор хэмжиж үзэхэд инвертерийн байр доторх дуу шуугианы түвшин нь стандартын түвшнээс давсан буюу 78.16 дБА байна.




2.2-р зураг. Төслийн талбай орчимд хийгдсэн дуу шуугианы хэмжилтийн түвшин

2.7 Хөрсөн бүрхэвч

2.7.1 Хөрсний тархалт

Нарны цахилгаан станцын талбайд сайргархаг хар хүрэн, дунд зэрэг зузаан ялзмагт давхаргатай хар хүрэн, нугархаг хүрэн хөрс тархсан.



2.3-р зураг. Төслийн талбайн хөрсөн бүрхэвч, дээж авсан цэг

2024 онд төслийн талбайд ашиглалтын үед хөрсөнд үзүүлэх нөлөөлөл бага байсан ч нугархаг хар хүрэн хөрсний ялзмаг буурсан, рН нь хүчиллэг тал руу болсон, мг/100 г хөрсөнд хөдөлгөөнт фосфорын агууламж бага зэрэг буурсан, калийн агууламж бага зэрэг өссөн байна.

Дунд зэрэг зузаан ялзмагт давхаргатай хар хүрэн хөрсний ялзмаг бага зэрэг буурсан, рН нь хүчиллэг тал руу болсон, мг/100г хөрсөнд хөдөлгөөнт фосфорын агууламж бага зэрэг буурсан, калийн агууламж бага зэрэг өссөн байна.

Сайргархаг хар хүрэн хөрсний ялзмаг буурсан, рН нь хүчиллэг тал руу болсон, мг/100г хөрсөнд хөдөлгөөнт фосфорын агууламж хэвийн хэмжээндээ, калийн агууламж өссөн байна.

2.4-р хүснэгт. Хөрсний химийн шинж чанарын өөрчлөлтийн байдал

Хөрсний төрөл	Дээж авсан цэг	Дээж авсан он	Ялзмаг, %	CaCO ₃ , %	pH	Хөдөлгөөнт шим тэжээлийн бодис, мг/100г хөрсөнд	
						P ₂ O ₅	K ₂ O
Нугархаг хар хүрэн хөрс	105°56’37.7” 49°23’56.3”	2015	2.47	-	7.6	2.6	16
		2021	1.002	0.00	7.25	1.25	18.5
Өөрчлөлт			-1.468		-0.35	-1.35	2.5
Дунд зэрэг зузаан ялзмагт давхаргатай хар хүрэн хөрс	105°56’26.8” 49°23’57.4”	2015	2.01	-	7.5	1.8	13
		2021	1.100	0.00	6.97	1.42	17.7
Өөрчлөлт			-0.91		-0.53	-0.38	4.7
Сайргархаг хар хүрэн хөрс	105°56’29.3” 49°24’00.9”	2015	1.57	-	7.4	1.3	12
		2021	1.202	0.00	6.85	1.46	19.2
Өөрчлөлт			-0.368		-0.55	0.16	7.2

Дээрх 3 төрлийн хөрсний шимт чанарын үзүүлэлтүүдийн бага зэрэг өөрчлөлтийн хандлага нь адилавар буюу ялзмаг нь бага зэрэг буурах, хүчиллэг шинж нь ихсэх, фосфорын агууламж буурч болох, харин калийн агууламж нэмэгдэх хандлага ажиглагдаж байна. Энд ерөнхийдөө ялзмагийн хэмжээ буурах хандлага гарсан байж болохоор байгаа ч хөрсний химийн шинж чанарыг өөрчлөлттэй байна гэж үзэхээргүй бага үзүүлэлттэй өөрчлөлт гарсан байна.


Нарны зайн сүүдэр хэсэгт дээж авч хөрсний физик, химийн шинж чанар өөрчлөгдсөн эсэхийг шинжлүүлэхэд хөрсний механик бүрэлдэхүүний шинжид гарсан өөрчлөлтгүй, түүнчлэн сүүдэрт хөдөлгөөнт калийн хэмжээ ялимгүй бага хэдий ч шим тэжээлийн бодист мэдэгдэхүйц өөрчлөлт гараагүй байна.

2.7.2 Хөрсний бохирдол, элэгдэл, эвдрэлийн одоогийн байдал.

Төслийн 291784 м² талбайн хувьд 524.1 м² талбайд инвертерийн 8 байр барьсан, оффисын барилгыг 446.6 м², зогсоол талбайн 1078.25 м², хуваарилах байгууламжийг 693.2 м², худгийн байр 4 м², нийтдээ 2746.2 м² талбайд хөрсөн бүрхэвч дарагдсан байна. Нарны зайн цахилгааны холболтын газар доогуурх кабелийн багцын сүлжээ хийсэн газруудад хөрсийг өндөр овоолсон зарим газарт хөрсний гадарга эргэж хэвийн түвшиндээ ороогүй, ургамлын бүрхэц үүсээгүй байсан. Мөн хашаан дотор технологийн ажлын зориулалтаар шороон замууд ашиглагдаж байгаагийн зэрэгцээ түүнийг дагаж зарим газар элэгдэл үүссэн байна.



2.4-р зураг. Овоолсон хөрсөнд ургамлын бүрхэвч үүсэх нь удаан байна.



2.5-р зураг. Авто зам болон элэгдэл үүссэн газрууд

Оффисын барилгын талбайн эргэн тойрон, зогсоолын талбайг тохижуулан хайрган хучилт хийсэн нь хөрсний элэгдэл эвдрэлээс сэргийлсэн арга хэмжээ болсон байна.

Өмнө нь 2015 онд хийсэн хүнд элементүүдийн агууламжийг 2021 онд хийсэн хүнд элементүүдийн агууламжийг харьцуулж үзэхэд цайр 2 дээжид бага зэрэг их байсныг эс тооцвол бусад элементүүдийн агууламж ойролцоо утгатай байна. Энэ нь хүнд элементүүдийн бохирдолгүй болохыг илтгэж байна.

2.5-р хүснэгт. Төслийн талбайн хөрсөнд агуулагдах хүнд металлуудын хэмжээ, мг/кг

Зүсэлтийн дугаар	Pb	Cd	Cr	Zn	Ni
15(1) - 02	21.4	0.26	12.8	35.7	7.9
15(1) - 03	11.4	0.18	21.2	77.9	17.9
15(1) - 01	11.0	0.09	15.4	63.5	12.4
Элсэнцэр хөрсөнд зөвшөөрөгдөх(хүлцэх) дээд хэмжээ					

2.6-р хүснэгт . 2024 онд авсан дээжийн хүнд элементүүдийн агууламж, %, мг/кг

Лабораторийн дугаар	Дээжийн дугаар	Элемент, %				
		Al*	Ca	Mg	K	Fe нийт
17729	SS-001	4.08	1.88	0.42	2.32	2.72
17730	SS-003	4.55	1.96	0.52	2.45	2.52
17731	SS-004	4.61	1.91	0.46	2.48	2.72
Стандарт (MNS 5850 : 2019)-ын хүлцэх агууламж		-	-	-	-	-

үргэлжлэл

Лабораторийн дугаар	Дээжийн дугаар	Элемент, мг/кг							
		As	Ba*	Be	Bi	Cd	Co	Cr	Cu
17729	SS-001	<5.0	538.3	<5.0	<10.0	<1.0	14.67	48.04	13.68
17730	SS-003	5.68	611.9	<5.0	<10.0	<1.0	14.30	48.68	33.39
17731	SS-004	<5.0	491.4	<5.0	<10.0	<1.0	15.10	47.85	11.31
Стандарт (MNS 5850: 2019)-ын хүлцэх агууламж		20				3.0	50.0	150	100

үргэлжлэл

Лабораторийн дугаар	Дээжийн дугаар	Элемент, мг/кг							
		La	Li	Mn	Mo	Ni	P	Pb	Sb
17729	SS-001	10.3 6	13.09	519. 7	16.76	16.7 6	590. 8	9.98	<10.0
17730	SS-003	17.3 5	19.25	521. 8	18.21	18.2 1	560. 2	8.23	<10.0
17731	SS-004	11.4 6	14.25	527. 6	17.59	17.5 9	601. 5	7.88	<10.0
Стандарт (MNS 5850 : 2019)-ын хүлцэх агууламж					5.0	150		100	

Лаборатори йн дугаар	Дээжийн дугаар	Элемент, мг/кг						
		Se	Sr*	Ti	V	Y	Zn	Zr*
17729	SS-001	<5.0	232.7	4855	89.91	13.39	52.28	88.94
17730	SS-003	<5.0	278.3	4319	87.35	15.38	52.74	8681
17731	SS-004	<5.0	247.1	5106	93.56	14.08	49.15	98.11
Стандарт (MNS 5850 : 2019)-ын хүлцэх агууламж		10.0	800		150.0		300	

2.8 Ургамлан нөмрөг

Төслийн талбайд барилга байгууламж, тоног төхөөрөмж бүрэн суурилагдан хашаалагдсанаас хойш 5 жил болсон бөгөөд оффисын барилга, түүний зогсоол талбай, худгийн байр, инвертерийн 8 барилга, цахилгаан хуваарилах байгууламж суурилуулсан талбайд нийтдээ ургамал бүхий 2746.2 м² талбай өртсөн байна.

Төслийн талбайд ширэг улалж зонхилсон *улалж-харганат* эвшил зонхилон тархсан. Ургамлын бүрхцийн хувьд 70-90 хувь орчим, энэ жил бороо хур сайтай байсан учраас талбайг ургамлаар жигд бүрхэгдсэн байна. Төслийн талбайд өмнө нь бүртгэгдсэн ургамлын зүйлийн бүрдэл нэмэгдсэн байна.

Нарны зайн доод ирмэгийн сүүдэрлэгдсэн хэсгийн дагууд ургамал зарим газарт устгах, зарим хэсэгт сийрэгжиж ургалт нь багасах нөлөөлөлд өртсөн байна. Үүнийг бид урьдчилсан байдлаар баруун хойдоос зүүн хойд чиглэл хоорондох салхины хүч ихэссэн үед 45° налуу байрлалтай нарны зайн ар тал руу түүний налуу дагуу салхины урсгал чиглэн доод нарийн зайгаар гарах агаарын урсгалын даралт нь ихсэж, хөндлөн бэхэлгээний төмөрт тулах зэргээс хуйлралын чиглэл, хүч өөрчлөгдөн нөлөөлсөн байж болох, эсвэл нарны зайг угаах ус болон хурын ус нарны зайн нүүрийг дагаж урсахдаа нарны зайн угсралтын зайгаар доош унаж гоожсон хэсэгт урсгалын хүчний нөлөөгөөр ургамал, хөрс халцрах нөлөөлөл үүсэж болох зэргийг ялган үзэх мониторинг хийх хэрэгтэй гэж үзлээ. Өөр нөлөөлөл байхыг үгүйсгэхгүй.





2.6-р зураг. Ургамал багасаж, хөрс элэгдсэн газар

Бага хэмжээний алаг цоог газарт хөрсөн бүрхүүл ургамалгүй болсон нь салхины улмаас тоос шороо босож нарны зайн нүүрэнд тоос тогтох нөхцөл бүрдсэн байна.



2.7-р зураг. Ургамлан нөмрөггүй байгаа газрууд

Экологи, газарзүйн байрлал, ургамлан нөмрөгийн тархцын зүй тогтлын ерөнхий төлөвөөрөө энд байх боломжтой цөөнгүй тооны ургамал бий боловч олон жил талхлагдалд орсноос ургамлын тархцын алдагдсан унаган төрх нь хашаалсны улмаас байгалийн төрхөд ойртох сэргэлтийн явц үргэлжилж, ургамлын зүйлийн бүрдэл нэмэгдэж хуучин төрхдөө ойртох боломжтой байна гэж үзэхээр байна.

Төслийн талбайд мод услах, нарны зай угаах ажлын үед тээврийн хэрэгслээр зорчин ургамал бүрхэвчийг бага зэрэг талхлах нөлөө үүсдэг байна. Худгаас дээших замын хэсэг ургамалгүй болсон талбай ажиглагдаж байна.

Тарьсан ургамлууд. Төслийн талбайн хойд захаар агч мод 250 ширхэг, зүүн захын хойд, урд хэсэгт гацуур 60 ширхгийг тарьсан нь сайн ургаж байна. Түүнчлэн компани ажиллагсдынхаа хүнсний хэрэгцээнд зориулж 2 хүлэмжид хүнсний ногоо тарьж ашигладаг байна.



2.8-р зураг. Төслийн талбайд тарьсан гацуур, агч мод



2.9-р зураг. Хүнсний ногооны хүлэмж

Ховор, нэн ховор ургамал. Хээрийн судалгааны үед төслийн 29 га талбайд нэн ховор, ховор ургамал ажиглагдаагүй болно.

2.9 Амьтны аймаг

Дархан хот байгуулагдсан цагаас хойш байгалийн экосистемийн унаган төрх алдагдаж, дэд бүтцийн салбар дахь хөгжлийг дагалдан үйлдвэр аж ахуйн газрууд орон сууцны хороолол, гэр хороолол нэмэгдсээр эдэлбэр нутаг, хүрээлэн байгаа орчиндоо үзүүлэх сөрөг нөлөө улам бүр өссөөр ирсэн. Ийнхүү төсөл хэрэгжиж буй тус хотын үйлдвэрийн районоос холгүй орших дэд бүтцийн сүлжээ бүхий газарт амьтны аймгийн экосистемийн шинж төрх нэлээд алдагдаж энэ хавийн амьтны зүйлийн бүрдэл нь хот суурин, хүний ойр орчимд амьдрах синантроп зүйлүүд зонхилох болсон.

2.10 Тусгай хамгаалалттай газар нутаг

Дархан-Уул аймгийн нутаг дэвсгэрт улсын тусгай хамгаалалтад авсан газар одоогийн байдлаар байхгүй. Харин орон нутгийн хамгаалалтад Шийрийн хөндий, Талын толгой, Хустын булаг, Сонгино, Мөөл, Дархан уул хайрхан, Хараа гол, Шаазгайт, Могойн ам, Хойд хүйтний ам зэрэг газруудыг авсан байна. Дээрх тусгай хамгаалалттай нутгуудаас төслийн талбайд хамгийн ойр нь Шийрийн хөндий, Талын толгойн хамгаалалттай газар байх ба уг тусгай хамгаалалттай газрын баруун зах нь НЦС-ын талбайгаас 3.8 км зайд оршино.

Төслийн зүгээс энэ газар руу үйл ажиллагаа явуулахгүй тул уг газарт төслийн нөлөөлөл үүсэхгүй болно. Харин бусад орон нутгийн хамгаалалттай газрууд төслийн талбайгаас 15 -өөс 50 км зайд алслагдсан байна.

2.11 Соёлын өв

Төслийн талбайд гадарга дээр түүх соёлын дурсгал хээрийн судалгааны үед ажиглагдаагүй. Талбайн баруун талын өндөрлөг дээр бөөгийн ёслолын овоо босгосон нь талбайн хилээс 80 гаруй м зайд өмнөх үеийн /2015 оны/ байдлаас өөрчлөгдөөгүй байна.



2.10-р зураг. Бөөгийн ёслолын овоо /49°24'1.0", 105°56'12.3"/

2.12 Нийгэм эдийн засгийн байдал

Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт 2024 оны байдлаар 1548 өрхийн 5796 хүн амьдарч байсан. Эдийн засгийн хувьд уг суманд мал аж ахуй, газар тариалан их хөгжсөн байна. Нарны цахилгаан станц байгуулагдсанаас хойш 10 гаруй хүнийг ажлын байраар хангаснаас гадна эрчим хүчний хангамжийг нэмэгдүүлж, бизнесийн таатай орчин бүрдэж байгаа юм.

3 ДУГААР БҮЛЭГ. ТӨСЛИЙН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛҮҮД

Нарны станцын үйл ажиллагааны үеийн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл, түүний сөрөг үр дагаврыг багасгах, арилгах арга замыг дараах хүснэгтэд өгөв.

3.1-р хүснэгт. Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн жагсаалт

№	Болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зөвлөмж
1. Байгалийн физик нөөц		
1.1. Агаарын чанар		
1.1.1	Агаар мандал бохирдох	- Тоосжилтын хяналтыг тоосжилт үүсэх эх үүсвэрүүд болон ажлын байранд тогтмол хийж, ихэссэн үед нь тоосжилт дарах арга хэмжээ авах
		- Үйл ажиллагаандаа аль болох машин техник бага хэрэглэн журамлах
1.1.2	Дуу шуугианы бохирдол үүсэх	- Ажилчид хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн талаар хэрэгжүүлж ажиллагсдад сонсголын эрхтэн хамгаалах хэрэгсэл хэрэглүүлж хэвшүүлэх
1.2. Усан орчин		
1.2.1	Газар доорх усны горим, нөөц өөрчлөгдөх	- Худгийн усыг зөв зохистой, үр ашигтай зарцуулах
		- Худгийн тоолуур тавих
		- Усны ашиглах төлбөр тооцоог холбогдох байгууллагад жил бүр төлөх
1.2.2	Газар доорх ус бохирдох	- Үйлдвэрлэлийн осол гэмтэл гарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлэх
		- Бохир ус дамжуулах хоолойн холбоосуудаар ус алдагдаж байгаа эсэхийг хянах, тухай бүр нэн даруй засвар хийх
1.3. Хөрсөн бүрхэвч		
1.3.1	Хөрсний температур, чийгшлийн горим алдагдах	- Хөрсний чийгийн мониторинг хийх

№	Болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зөвлөмж
1.3.2	Хөрсний бүтэц, шимт чанар өөрчлөгдөх	- Хөрс нь элэгдсэн, сул шороотой байгаа алаг цоог газруудыг бүртгэж, хөрсийг сийрэгжүүлэн олон наст ургамлын үр тарьж, хөрсийг хамгаалах арга хэмжээ авах
1.3.3	Хөрсөн бүрхэвч бохирдох	- Шатахуун, тос, тосолгооны материал хөрсөнд асгарч алдагдвал тус бохирдлыг саармагжуулах, арилгах арга хэмжээ авах нэн даруй авах
2. Экологийн нөөц		
2.1. Ургамал		
2.1.1	Ургамал ургах орчны доройтол	- Ургамал нөмрөггүй болсон газруудыг ургамалжуулах, олон наст ургамлын үр цацах
		- Нарны зайн сүүдэрлэгдсэн талбайн ургамалжилтад мониторинг хийж нөлөөллийг тодруулан тохирох арга хэмжээ авах,
		- Ногоон байгууламжийн дунд ургасан шарилж зэрэг хогийн ургамлыг үр боловсрохоос нь өмнө зулгааж устгах, усалгаа арчилгааг тогтмол хийх
		- Станцын талбайд тариалсан ургамлуудад арчилгааг сайн хийх, шинээр тарьсан ургамлан бүрхэвч муудахаас сэргийлж мониторинг байнга хийж байх
3. Нийгмийн /Амьдралын үнэт зүйлс/		
3.1. Эрүүл мэндийн		
3.1.1	Ажиллагсдын аюулгүй байдал	- Тоног төхөөрөмж, холболтуудын бэхэлгээ, бүрэн бүтэн байдалд үзлэг, цахилгааны шугамын холболтуудыг хянаж засварлаж байх, ГОББТ боловсруулж ажиллах
		- Нийт ажилчдад техник ашиглалтын дүрэм /ТАД/, аюулгүй ажиллагааны дүрэм зааварчилгааг тогтмол өгөх
		- Ажилчдад анхны тусламж үзүүлэх арга зааврыг эзэмшүүлэх, Анхан шатны тусламжийн эм, тариа, багажийг ажлын байранд байрлуулах
		- Ажлын байрны аюулгүй ажиллагааг хангаж ажиллах
3.2. Хог хаягдал		
3.2.1	Ахуйн хаягдал хог	- Хог хаягдлыг /цаас, хуванцар, ахуйн буюу хоолны үлдэгдэл гэх мэтээр/ ангилан ялгаж, дахин ашиглаж болох хаягдлыг хоёрдогч түүхийн авагч иргэдтэй гэрээ хийж худалдаалах
		- Ажилчдыг станцын талбайд ил задгай хог хаягдал хаяхгүй байх талаар анхааруулга өгч тэмдэг тэмдэглэгээ тавих
		- Хог хаягдлын нөлөөллийн бууруулах арга хэмжээний зөвлөмжид заасан шиг ангилан ялгадаг хогийн савыг байршуулах
		- Бохир усыг хадгалах савнаас халиахгүй байж тогтмол соруулан зайлуулж байх
		- Дулаан цагт бохирын цооногт нян бактери үүсэж, орчинд эвгүй үнэр тархахгүй байх нөхцөлийг бүрдүүлж ариутгалын бодис хийх
		- Бохирын цооногт био ялзралын процесс явагддаг учир цэвэрлэгээ үйлчилгээг мэргэжлийн хүнээр хийлгэх

№	Болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зөвлөмж
3.2.2	Технологийн хог хаягдал	- Станцад хэрэглэгдэж буй зургаан фторт хүхэрт хий болон трансформаторын тосыг солих үед аюулгүй ажиллагааны дүрмийг хэрэгжүүлж, алдагдал хаягдалгүй ажиллах, алдагдал гарсан нөхцөлд зохих шаардлагын дагуу устган хоргүйжүүлэх
		- Гэмтсэн нарны зайн хаягдлыг нийлүүлэгчид буцааж нийлүүлэх

4 ДҮГЭЭР БҮЛЭГ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Энэхүү төлөвлөгөөний зорилго нь 10 МВт-ын нарны цахилгаан станцын үйл ажиллагааны үед үүсэх сөрөг нөлөөлөл, түүнийг бууруулах арга хэмжээг тодорхойлж, үүнийхээ дагуу 2021-2025 онд нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, бохирдлоос сэргийлэх, ерөнхий үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх, байгаль орчныг хамгаалах талаар компанийн зүгээс авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодотгосон дүнг үндэслэн тухайн жилийн үйлдвэрлэлийн төлөвлөгөөтэй уялдуулан тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг хянуулж ажиллахад оршино.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрөөс бүрдсэн.

5 ДУГААР БҮЛЭГ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал (төгрөг)	Баримтлах эрх зүйн баримт бичиг, стандарт
Цаг агаарын гэнэтийн хувирал өөрчлөлт үүсэж, цаг агаарын үзэгдэл, хур тунадасны эрч хүч нэмэгдэх, аянга цахилгаантай аадар орох тохиолдол олшрох	Нарны зайн эвдрэл, гэмтэл үүсэхээс сэргийлсэн арга хэмжээ тухай бүр авч хэрэгжүүлэх	Нарны зай	-	-	-	-	-
Машины хөдөлгөөн болон хөрсний элэгдлээс тоосжилт үүсэх	Төслийн талбайд алаг цоог ургамлан бүрхэвчгүй ил хөрсөн гадарга байгаа нь тоосжилт үүсгэх эх үүсвэр болох учир тоосжилтыг багасгах буюу ургамалжуулах арга хэмжээг авч, хяналтдаа байлгах	Станцын талбай	Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөнд тусгасан				-
Станцын үйл ажиллагаанд ашигладаг авто машинуудаас хорт хий ялгарах	Үйл ажиллагаандаа аль болох хорт хийн ялгарлын стандартын шаардлага хангасан машин техник хэрэглэж байх	Үйл ажиллагаанд ашиглах авто машинууд	-	-	-	-	Агаарын тухай хууль, MNS 5014:2009, MNS 5013:2009

Сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал (төгрөг)	Баримтлах эрх зүйн баримт бичиг, стандарт
Станцын тоног төхөөрөмжүүдээс шуугиан үүсэх	Ажилчид хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн талаар хэрэгжүүлж ажиллагсдад сонсголын эрхтэн хамгаалах хэрэгсэл хэрэглүүлж хэвшүүлэх	Станцын ажилчид	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөнд тусгав				Агаарын тухай хууль, “MNS 4585 :2016” Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага
Усны хэрэглээг хяналтгүй зарцуулснаас ундны усны нөөц хомсдох	Усны боломжит нөөцийн дүгнэлтийг Дархан-Уул аймгийн БОАЖГ-аар гаргуулах	Станцын талбай дах гүний худаг	-	-	-	-	Усны тухай хуулийн 28.4 заалт
	Худгийн усыг зөв зохистой, үр ашигтай зарцуулах		-	-	-	-	Усны тухай хууль
	Худгийн тоолуур тавих		ш	50,000	1	50,000	Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам
	Усны ашиглах төлбөр тооцоог холбогдох байгууллагад жил бүр төлөх		Компанийн үйл ажиллагааны зардлаас				Усны тухай хууль
Үйл ажиллагаанд хэрэглэх машин механизм, техник хэрэгслүүдийн, тоног төхөөрөмжийн тослох материал хөрсөнд асгарч шингэснээр газар доорх ус бохирдох	Үйлдвэрлэлийн осол гэмтэл гарч тос шатахуун алдагдахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлэх	Станцын талбай орчим	-	-	-	-	Усны нөөцийг бохирдлоос хамгаалах дүрэм

Сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал (төгрөг)	Баримтлах эрх зүйн баримт бичиг, стандарт
Бохир ус хадгалах цооногийн сан халих, холболт задлах, шүүрэх зэргээс газар доорх усыг бохирдох	Бохир ус дамжуулах хоолойн холбоосуудаар ус алдагдаж байгаа эсэхийг хянах, тухай бүр нэн даруй засвар хийх	Станцын талбай дахь бохирын цооног	удаа	200,000	-	200,000	Усны нөөцийг бохирдлоос хамгаалах дүрэм
Авто машинуудын шороон зам үүсэж хөрсний элэгдэл эвдрэл үүсэх	Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг журамлан чөлөөт зорчилт хийхийг хориглох	Авто машины хөдөлгөөн	-	-	-	-	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль
Хөрсний элэгдэл, эвдрэл ихсэх	Хөрс нь элэгдсэн, сул шороотой байгаа алаг цоог газруудыг бүртгэж, хөрсийг сийрэгжүүлэн олон наст ургамлын үр тарьж, хөрсийг хамгаалах арга хэмжээ авах	Төслийн талбай	Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөнд тусгасан				Хөрс хамгаалах тухай хууль
Үйл ажиллагаанд хэрэглэх машин механизм, техник хэрэгслүүдийн тослох материал хөрсөнд асгарах	Үйлдвэрлэлийн осол гэмтэл гарч тос шатахуун алдагдахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлэх	Станцын талбай орчим	-	-	-	-	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай
Трансформатор тос хөрсөнд алдагдах	Трансформаторын тос хөрсөнд асгарч алдагдвал тус бохирдлыг саармагжуулах, арилгах арга хэмжээ авах нэн даруй авах, хуваарилах байгууламжийн тосны алдагдал цуглуулах суваг,	Станцын талбайн хөрсөн бүрхэвч	м³	300,000	-	300,000	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай

Сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжигч нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал (төгрөг)	Баримтлах эрх зүйн баримт бичиг, стандарт
	нүхний битүүмжийг тогтмол хянаж байх						
Нарны дэлгэцэд сүүдэрлэгдсэн талбайн хөрсний элэгдэл ихсэх	хөрсний элэгдэлд ажиглалт мониторинг хийж, шалтгааныг тодорхойлж, хөрсний элэгдлээс сэргийлэх арга хэмжээ авч байх	Нарны зай байрлуулсан талбай	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгасан				Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай
Нарны дэлгэцэд сүүдэрлэгдсэн талбайн ургамлын ургах орчин доройтох	Ургамал нөмрөггүй болсон газруудыг ургамалжуулах, олон наст ургамлын үр тарьж ургамалжуулах	Станцын талбайн ургамлан нөмрөг	Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөнд тусгасан				MNS 5918 : 2008 Эвдэрсэн газрыг ургамалжуулах
	Нарны зайн сүүдэрлэгдсэн талбайн ургамалжилтад мониторинг хийж нөлөөллийг тодруулан тохирох арга хэмжээ авах	Нарны зайн сүүдэрлэгдсэн талбайн ургамлан нөмрөг	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгасан				Ургамал хамгааллын тухай хууль
Шарилж зэрэг хогийн ургамал ихсэх	Станцын талбайд шарилж зэрэг хогийн ургамлыг үр боловсрохоос нь өмнө зулгааж устгах, шаардлагатай тохиолдолд мэргэжлийн байгууллагаар устгал хийлгэх	Станцын талбайн ургамлан нөмрөг	Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөнд тусгасан				Ургамал хамгааллын тухай хууль
Нөхөн сэргээсэн ургамлуудын ургалт муудах	Станцын талбайд тариалсан ургамлуудад арчилгааг сайн хийх, шинээр тарьсан ургамлан бүрхэвч муудахаас сэргийлж мониторинг байнга хийж байх	Станцын талбайд шинээр тарьсан ургамлан нөмрөг	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгасан				Ургамал хамгааллын тухай хууль, MNS 6260 : 2011 Зүлэгжүүлэх талбай бэлтгэх, үр тарих, арчлах

Сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал (төгрөг)	Баримтлах эрх зүйн баримт бичиг, стандарт
Нийт дүн				500,000		500,000	

6 ДУГААР БҮЛЭГ. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал (төгрөг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг, стандарт
Ургамалжуулах	Хог ургамал устгах арга хэмжээ авах	Станцын талбай дахь ургамлан нөмрөгт	-	60,000	-	300,000	2025 онд онд жил бүр	Байгалийн ургамлын тухай хууль MNS 5918:2008 Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн шаардлага MNS 6260 : 2011 Зүлэгжүүлэх талбай бэлтгэх, үр тарих, арчлах
	Ургамалгүй болсон талбайг шинээр ургамалжуулах олон наст ургамлын үр цацах	Станцын талбай дахь ургамалгүй болсон талбай	м ²	20,000	4.2 м ²	150,000	2025 онд	
Нийт дүн				80,000		450,000		

7 ДУГААР БҮЛЭГ. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төгрөг	Нийт зардал, төгрөг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Станцын талбайд түүх соёлын дурсгалт өв байхгүй учир тусгайлан менежментийн төлөвлөгөө боловсруулах шаардлагагүй гэж үзлээ							

8 ДУГААР БҮЛЭГ. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал (төгрөг)	Нийт зардал (төгрөг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг, стандарт
Үер усны аюулын улмаас талбайг хамарсан хөрсний нил угаагдал үүсэж элэгдэл, тоног төхөөрөмж унаж эвдрэл гэмтэл бий болох	Үер уснаас урьдчилсан сэргийлэх арга хэмжээг авах, хүчтэй аадар борооны үед цахилгаан хэрэгслийг хүчдэлээс салгах, газардуулга, бусад холболтын байдалд хяналт, үзлэг хийж байх	Станцын талбай дах тоног төхөөрөмжүүд	-	-	-	2025 онд тогтмол	Гамшгаас хамгаалах тухай хууль
Гал түймэр үүсэх аюул	Төслийн талбайд ил гао гаргахгүй байж болзошгүй аюул ослын үед ашиглах бүрэн ажиллагаатай гал унтраах анхан шатны багаж хэрэгслийг байрлуулах, Онцгой байдлын газартай хамтарч гэнэтийн гал түймэр, гамшиг осолтой тэмцэх аргачилсан заавар зөвлөгөөг боловсруулах	Станцын талбай орчим	ш	100,000	100,000	2025 онд	Гамшгаас хамгаалах тухай хууль
Аянга цахилгааны улмаас гал түймэр, тэсрэлт дэлбэрэлт гарах, хэт хүчдэл үүсэх, эрүүл мэнд амь насны хохирол үүсэх	Аянга зайлуулагч, газардуулгын бүрэн бүтэн байдлыг хянах, хэт хүчдэлийн хамгаалалтыг шалгах, тохируулах	Станцын тоног төхөөрөмжүүд, нийт ажиллагсад	-	-	-	2025 онд тогтмол	Гамшгаас хамгаалах тухай хууль
Газар хөдлөлтийн улмаас барилга	Тоног төхөөрөмж, холболтуудын бэхэлгээ, бүрэн	Станцын тоног		Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгав			Гамшгаас хамгаалах тухай хууль

Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал (төгрөг)	Нийт зардал (төгрөг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг, стандарт
байгууламж нурах зэргээр хүний эрүүл мэнд, амь нас, эд хөрөнгө сүйрэх	бүтэн байдалд үзлэг, цахилгааны шугамын холболтуудыг хянаж засварлаж байх, ГОББТ боловсруулж ажиллах	төхөөрөмжүүд , нийт ажиллагсад					
Хүний эрүүл мэнд амь нас хохирох	Нийт ажилчдад техник ашиглалтын дүрэм /ТАД/, аюулгүй ажиллагааны дүрэм зааварчилгааг тогтмол өгөх	Нийт ажиллагсад	-		Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгав		Хөдөлмөрийн аюулгүй байдал, Эрүүл ахуйн тухай хууль, MNS 4968:2000
	Ажилчдад анхны тусламж үзүүлэх арга зааврыг эзэмшүүлэх, анхан шатны тусламжийн эм, тариа, багажийг ажлын байранд байрлуулах	Нийт ажиллагсад			Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгав		Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд тавих ерөнхий шаардлага,
Нийт дүн				100,000	100,000		

9 ДҮГЭЭР БҮЛЭГ. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал (төгрөг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг, стандарт
Хатуу хог хаягдал	Хог хаягдлыг /цаас, хуванцар, ахуйн буюу хоолны үлдэгдэл гэх мэтээр/ ангилан ялгаж, дахин ашиглаж болох хаягдлыг хоёрдогч түүхийн авагч иргэдтэй гэрээ хийж худалдаалах	Станцын талбай, түүний орчимд	-	-	-	-	2025 онд, сар бүр	Хог хаягдлын тухай хууль
	Ажилчдыг станцын талбайд ил задгай хог хаягдал хаяхгүй байх талаар анхааруулга өгч тэмдэг тэмдэглэгээ тавих	Станцын талбай, түүний орчимд	ш	20,000	Ажлын байран дотор болон станцын талбайн гадна, нийт 2 ш	40,000	2025 онд	Хог хаягдлын тухай хууль
	Хог хаягдлын нөлөөллийн бууруулах арга хэмжээний зөвлөмжид заасан шиг ангилан ялгадаг хогийн савыг байршуулах /Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тайлангийн 5.1-р зураг/	Станцын талбай, түүний орчимд	багц	20,000	1	40,000	2025 онд	Хог хаягдлын тухай хууль
Шингэн хог хаягдал	Бохир усыг хадгалах савнаас халиахгүй байж тогтмол соруулан зайлуулж байх	Станцын талбай, түүний орчимд	удаа	-	-	Бохир ус соруулах байгууллагатай гэрээ хийсний дагуу	2025 онд онд тогтмол	Хог хаягдлын тухай хууль

Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал (төгрөг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг, стандарт
	Дулаан цагт бохирын цооногт нян бактери үүсэж, орчинд эвгүй үнэр тархахгүй байх нөхцөлийг бүрдүүлж ариутгалын бодис хийх	Станцын талбай, түүний орчимд	удаа	30,000	-	30,000	2025 онд онд, жил бүрийн 7-р сард	Хог хаягдлын тухай хууль
	Бохирын цооногт био ялзралын процесс явагддаг учир цэвэрлэгээ үйлчилгээг мэргэжлийн хүнээр хийлгэх	Станцын талбай, түүний орчимд	удаа	Мэргэжлийн байгууллагатай хийсэн гэрээний дагуу			2025 онд онд, жил бүрийн 7-р сард	Хог хаягдлын тухай хууль
Технологийн хог хаягдал	Станцад хэрэглэгдэж буй зургаан фторт хүхэрт хий болон трансформаторын тосыг солих үед аюулгүй ажиллагааны дүрмийг хэрэгжүүлж, алдагдал хаягдалгүй ажиллах, алдагдал гарсан нөхцөлд зохих шаардлагын дагуу устган хоргүйжүүлэх	Станцын талбай, түүний орчимд	удаа	40,000	Алдагдал гарсан тухай бүрд	40,000	2025 онд онд, тухай бүрд	Хог хаягдлын тухай хууль
	Гэмтсэн нарны зайн хаягдлыг тусгай агуулахад хадгалж, нийлүүлэгчид буцааж нийлүүлэх	Станцын талбай, түүний орчимд	ш	Нийлүүлэгч байгууллагатай хийсэн гэрээний дагуу			2025 онд он	Хог хаягдлын тухай хууль
Нийт дүн				106,000		130,000		

10 ДУГААР БҮЛЭГ. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Нарны цахилгаан станцын үйл ажиллагаа явуулах үед байгаль орчинд үүсэж болзошгүй өөрчлөлт болон учруулах сөрөг нөлөөллийг хянаж байгаль орчинд гарсан өөрчлөлтийг тухай бүр илрүүлэх, түүнийг бууруулах, арилгах зорилгоор байгаль орчны төлөв байдалд тодорхой орон зайд, тодорхой хугацааны дотор, тодорхой давтамжтайгаар ажиглалт, хэмжилт, хяналт явуулах ёстой. Үүнд тулгуурлан үйл ажиллагааныхаа явцад байгаль орчинд учруулж буй нөлөөлөл, түүний хэмжээ, цар хүрээ, байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд гарч буй өөрчлөлтөд дүгнэлт хийж цаашид авах арга хэмжээг нарийвчлан төлөвлөж хэрэгжүүлнэ. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад байгаль орчны төлөв байдалд өөрчлөлт орох, бохирдлын хэмжээ байгаль орчны стандарт, норм нормативоор тогтоосон хэмжээнээс хэтэрч илрэх тохиолдолд мэргэжлийн байгууллагад яаралтай хандаж, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх хэрэгтэй.

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал (төгрөг)	Нийт зардал (төгрөг)	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
Агаарын бохирдол - Тоос - Агаар бохирдуулагч хорт хийнүүд	Станцын талбай	2025 онд онд жил бүр	7-р сард 1 удаа 1 цэгт	30,000	150,000		MNS 17.2.3.16-88 Хот суурин газрын агаарын чанарыг хянах журам MNS 3384-82 Агаар мандал. Сорьц авахад тавих үндсэн шаардлага MNS 4585 :2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS 5885 : 2008 Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага
Дуу шуугиан	Ажлын байранд	2025 онд онд жил бүр	7-р сард 1 удаа 1 цэгт	10,000	50,000		MNS 0012-9-015-87 Ажлын байранд шуугианыг хэмжих арга MNS 5002-2000 Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага
Хөрсний бохирдол - Бохирдлын голлох үзүүлэлтүүдээр	Станцын сонгосон талбай	2025 онд онд	7-р сард 1 удаа 2 цэгт	14,000	56,000		MNS 3298 – 1990. Хөрсний шинжилгээний дээж авахад тавигдах шаардлагууд MNS 5850 : 2008 Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
Хөрсний шинж чанар - Хөрсний элэгдэл, угаагдал	Нарны зайд сүүдэрлэгдсэн ба сүүдэрлэгдээгүй хэсгүүд	2025 онд онд жил бүр	7-р сард 2 цэгт	6,000	60,000		MNS 3298 – 1990. Хөрсний шинжилгээний дээж авахад тавигдах шаардлагууд
Ундны усны чанар - Ус ашиглалтын тайлан бүртгэл	Станцын талбай дахь гүний худаг	2025 онд онд жил бүр	1 ш гүний худагт	10,000	50,000		MNS 0900:2018Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ Усны анхан шатны тоо бүртгэл хөтлөх журам

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал (төгрөг)	Нийт зардал (төгрөг)	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
							Усны тоо бүртгэлийн тайлан гаргах журам

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал (төгрөг)	Нийт зардал (төгрөг)	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал (төгрөг)	Нийт зардал (төгрөг)	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
- Ундны усны чанарын үндсэн үзүүлэлтүүд							
Ургамалжилт -Ургамлын зүйл, бодгалийн тоо, бүрхэц, өөрчлөлт	Станцын талбай дахь нарны зайд сүүдэрлэгдсэн ба сүүдэрлэгдээгүй хэсгийн ургамлан нөмрөгт	2025 онд онд жил бүр	7-р сард 2 цэгт	40,000	100,000		Ургамлын хээрийн судалгааны аргачлал. Биологийн хүрээлэн
Нийт дүн				80,000	466,000		

11 ДҮГЭЭР БҮЛЭГ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь	Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
Станцын ажилчдад байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг хамгаалах талаар зөвлөмж мэдээлэл болон танилцуулж тараах материал өгөх	200,000	2025 онд	“Солар повер интернешинл” ХХК-ийн хариуцах албан тушаалтан	Байгууллагын дотоод журам
Станцын ажилчдад техник ашиглалтын дүрэм /ТАД/, аюулгүй ажиллагааны дүрэм зааварчилгааг тогтмол өгөх ажилчдад анхны тусламж үзүүлэх арга зааврыг эзэмшүүлэх	100,000	2025 онд	“Солар повер интернешинл” ХХК-ийн хариуцах албан тушаалтан	Байгууллагын дотоод журам
Ажлын байрны аюулгүй ажиллагааг бүрэн хангах, ажлын байрны эрүүл ахуйн шаардлагыг хангасан эсэх, аюулгүй ажиллагааны талаар мэргэжлийн байгууллагаар шинжилгээ хийлгэж дүгнэлт гаргуулах	-	2025 онд	“Солар повер интернешинл” ХХК-ийн хариуцах албан тушаалтан	Байгууллагын дотоод журам
Гамшгийн ослын бэлэн байдлын төлөвлөгөө боловсруулж ажиллах	100,000	2025 онд	“Солар повер интернешинл” ХХК-ийн хариуцах албан тушаалтан	Гамшгаас хамгаалах тухай хууль
Ус ашиглах дүгнэлт, зөвшөөрлийг бүрэн авах	-	2025 онд	“Солар повер интернешинл” ХХК-ийн хариуцах албан тушаалтан	Усны тухай хууль
Байгаль орчны менежмент төлөвлөгөө ба түүний биелэлтийн тайланг боловсруулах	500,000	2025 онд	“Солар повер интернешинл” ХХК-ийн хариуцах албан тушаалтан	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах хянан батлах, тайлагнах журам
Нийт дүн	900,000			

12 ДУГААР БҮЛЭГ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

БОМТ, БОМТ- ний хэрэгжилтийг тайлагнах оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан байгуулах тушаалтан/ажилтан	зохион албан	Зохион байгуулах газар
Дархан-Уул аймгийн Хонгор сумын иргэдийн төлөөлөгчдийн хурал	БОМТ тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж, иргэдийн төлөөлөгчдийн хурлаар оруулж танилцуулах	Тухайн жилд байгаль орчныг хамгаалах, орчны өөрчлөлтийг хянах хөтөлбөр агуулсан байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлуулахад санал авах	Жил бүрийн 11 дүгээр сарын 1-ны дотор	-	“Солар повер интернейшнл” ХХК-ийн хариуцах албан тушаалтан		Дархан-Уул аймгийн Хонгор сумын засаг даргын тамгын газар
Төрийн захиргааны төв байгууллага /БОАЖЯ/	БОМТ тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж, дараа оны БОМТ-ний төсөлтэй хамтатган ерөнхий үнэлгээ хийсэн байгууллагад хүргүүлнэ.	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тухай	Жил бүрийн 12 дугаар сарын 10-ны дотор	-	“Солар повер интернейшнл” ХХК-ийн хариуцах албан тушаалтан, “САТУ” ХХК		БОАЖЯ
Дархан-Уул аймгийн Хонгор сумын Засаг дарга	БОМТ тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж тайланг хүргүүлэх	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тухай	Жил бүрийн 11 дүгээр сарын 10-ны дотор	-	“Солар повер интернейшнл” ХХК-ийн хариуцах албан тушаалтан		Дархан-Уул аймгийн Хонгор сум

13 ДУГААР БҮЛЭГ. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ТӨСӨВ

№	Ажлын төрөл	Төсөвлөсөн зардал, төгрөг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төсөв	410,000
2	Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний төсөв	384,000
3	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний төсөв	100,000
4	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний төсөв	150,000
5	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний төсөв	900,000
6	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн төсөв	466,000
7	Дүйцүүлэн хамгаалах Тэрбум мо хөтөлбөрийн хүрээнд зулзагын нарсан ойг мод тарих	5,000,000
Нийт төсөв		7,320,000

2025 онд Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд 7.3 сая төгрөг зарцуулна.